

**УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	4
	2.1. Оршил.....	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
	2.7. Материаллаг байдлын сүүрх сонгосон үндэслэл, тайлбар.....	7
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
	2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
	2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
	2.11. Шилэн дансны мэдээлэл.....	9
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	15
	4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
	4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	17
	4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	19
	4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	21
	4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	22
	4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	24
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
УТУГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТҮЦ	Түргэн үйлчилгээний цэг
УБЦТС	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.14 № 06/428
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Үндэсний дата төв УТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Үндэсний дата төв УТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ эмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Үндэсний дата төв УТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Үндэсний дата төв УТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Үндэсний дата төв УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус УТҮГ-ын захирал Б.Батжаргал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Үндэсний дата төв УТҮГ 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Үндэсний дата төв УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Үндэсний дата төв УТҮГ санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс 2019 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 11-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Үндэсний дата төв УТҮГ-ын захиралд хүргүүлэхээр төлөвлөн, Эс Жи Эм Ди Аудит ХХК-ийн аудитын баг аудитыг хариуцаж хэрэгжүүлэв.

Үндэсний дата төв УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 01/31 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Үндэсний дата төв УТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Үндэсний дата төв УТҮГ нь “Монгол Улсын цахим үйлчилгээний дэд бүтэц, суурь хөгжлийг бид бэхжүүлнэ” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын шийдвэрээр Үндэсний дата төв УТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг Монгол Улсын үндэсний цахим мэдээллийн хадгалалт, хамгаалалт, боловсруулалтын үйлчилгээг эрхлэх гэж тодорхойлжээ.

Үндэсний дата төв УТҮГ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Үндэсний дата төв УТҮГ-ын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Иргэний хууль
- Төрийн нууцын тухай хууль
- Харилцаа холбооны тухай хууль

Тайлант хугацаанд тухайн байгууллагын мөрдөж буй бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

Үндэсний дата төв УТҮГ нь байгуулагдсан цагаасаа эхлэн төрийн байгууллагуудад мэдээллийн технологид суурилсан дата төвийн үйлчилгээнүүдийг, төрийн бүх байгууллагуудад “gov.mn” домэйн нэрийг тус тус үнэ төлбөргүй олгож, төрийн байгууллагуудын цахим хуудас, шуудан, “Gov.mn” домэйн нэрийн сервер, шилэн дансны систем, “ebarimt” систем, ТҮЦ машин гэх мэт томоохон төрийн үйлчилгээний системүүдийн хэвийн тасалдалгүй ажиллагааг ханган ажилладаг байна.

Монгол Улсад дижитал шилжилтийн экосистемийг бүрдүүлэх хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн суурь системүүдийн үндсэн хэсэг болох төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системийг бие даан хөгжүүлэн үйлчилгээнд нэвтрүүлж, 86 байгууллага хооронд 87 вэб сервисээр дамжуулан мэдээлэл солилцуулах боломжийг бүрдүүлжээ.

Цахим орчинд Монгол Улсын иргэнийг таних боломжийг бүрдүүлсэн танилт, нэвтрэлтийн нэгдсэн “ДАН” системийг дотоод хүний нөөцөд тулгуурлан 2018 оны 10 дугаар сард үйлчилгээнд “sso.gov.mn” домэйн нэрээр нэвтрүүлэн 21 байгууллага хандах эрх олгож, 8 байгууллагын 9 системийг холбон үйлчилгээнд нэвтрүүлсэн байна.

Улсын хэмжээнд ухаалаг төхөөрөмжийн нэгдсэн бүртгэлийн систем бий болгох, ухаалаг төхөөрөмжийн хулгайн гэмт хэргийг бууруулах зорилгоор Харилцаа холбооны зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газар болон үүрэн холбооны операторуудтай хамтран уг системийг “Smartdevice.mn” цахим хаягаар үйлчилгээнд нэвтрүүлжээ.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь

материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцээгүй байна. Энэ нь УСНББОУС өөрчлөлт, НББ-ийн болон холбогдох хуулиудын өөрчлөлт, шинэчлэлтийг тусгаагүй байна.

Үндэсний дата төв УТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Үндэсний дата төв УТҮГ санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Unicus” програм хангамж ашигладаг байна.

Үндэсний дата төв УТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөтэй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Үндэсний дата төв УТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1.0 хувиар сонгов.

Үндэсний Дата төв УТҮГ 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж санал дүгнэлт гаргахад шаардлагатай материаллаг байдлын түвшний суурь үзүүлэлтийг төлөвлөлтийн шатанд нийт зардлыг сонгох нь зохимжтой гэж үзэв. Эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс сонгосон суурь үзүүлэлтийг 1.0 хувиар тооцож, материаллаг байдлын түвшнийг урьдчилсан байдлаар 24.9 сая төгрөгөөр тогтоож, Маягт № Б201-ээр баталгаажуулсан. Аудитын гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн 1.0 хувийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс материаллаг байдлын түвшнийг 52.6 сая төгрөгөөр тооцов.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 10 чиглэлээр аудитын 27 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 22 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	(Сая төгрөгөөр)	
			Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	415.2	
	Дүн	4	415.2	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансыг 196.1 сая төгрөгөөр бүртгэх байсныг, 286.7 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө борлуулсны олзоор бүртгэсэн нь НББОУС16-ын 39 дүгээр зүйлд “дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ нэмэгдсэн байвал өсөлтийг бусад хэсэгт хүлээн зөвшөөрч, өмчийн хэсэгт дахин үнэлгээний нэмэгдэл нэрээр хуримтлуулан бүртгэнэ” гэсэн заалттай

зөрчилдөж байна. Иймээс дээрх гүйлгээг НББОУС 16 -ын 39 дүгээр зүйлийн дагуу залруулсан болно.

Энэ нь “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар тендер, худалдан авалт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хууль, журам, УСНББОУС-д нийцүүлсэн эсэх, гэрээт ажиллагсдын цалин, шимтгэлийн тооцоолол зэрэг асуудлуудыг авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Үндэсний дата төв УТҮГ-ын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 4,326.9 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 4,001.0 сая төгрөг буюу 92.5 хувьтай байгаа нь урсгал зардлын хэмнэлтээс шалтгаалсан байна. Үндэсний дата төв УТҮГ нь 2018 оны тайлант хугацаанд байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, томилолт зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсний төлбөр хураамжийн зардлууд хэмнэгдсэн байна.

Улсын төсвөөс 2,645.5 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 1,355.5 сая төгрөгийн орлого олсон байна.

Үйл ажиллагааны нэр төрөл нэмэгдэн орлогын төлөвлөгөөг биелүүлэн 118.1 сая төгрөгийн нэмэлт орлого олж Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн 224 тоот тушаалын дагуу зарцуулсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Үндэсний дата төв УТҮГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны мэдээллээр цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 32 удаагийн 236.4 сая төгрөгийн гүйлгээ, зарлагын 57 удаагийн 912.3 сая төгрөгийн гүйлгээг мэдээлсэн байна. Мөн тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн тайлан /хагас жилийн/, төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбар, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, тендер, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авалтын тайлан, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө гүйцэтгэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг зэргийг мэдээлсэн байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 40.4 сая төгрөгийн 2 алдаа зөрчлүүдийг арилгах зөвлөмж өгөгдсөнөөс 2018 оны жилийн эцсийн байдлаар, биелэлтийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Үндэсний дата төв УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Үндэсний дата төв УТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Үндэсний дата төв УТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

1.1 Илрүүлэлт:

ТҮЦ машины засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслийн үнэ, бэлэн мөнгө уншигчийн машин худалдан авсан болон урсгал засварын 373.3 сая төгрөгийн ажлуудад нээлтэй тендер шалгаруулалт зарлаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, 8 дугаар зүйлийн 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Эрсдэл:

- Холбогдох хууль журмыг хэрэгжүүлж ажиллаагүй

1.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5 дах заалтуудыг мөрдөж ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

ТҮЦ машины засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслийн үнэ болон урсгал засвар нь магадалшгүй байдаг тул эвдрэл гэмтлээс шалтгаалж завсар хийх нөхцөл байдал үүсдэг. Мөн дээрх засваруудын тус бүрийн төсөвт өртөг нь нээлттэй тендер зарлах босго үнэд хүрэхгүй байна. Нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийсэн үйлдэл байхгүй ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу тендер шалгаруулалтын онцгой журам “Харьцуулалтын арга”-ыг хэрэглэн ажилласан.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

2.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт шинэчлэлт, сайжруулалт хийгдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн баталж, мөрдөж ажиллана" гэж заасныг мөрдөөгүй, "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Эрсдэл:

- Холбогдох хууль журмыг хэрэгжүүлж ажиллаагүй.

2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дах заалтыг мөрдөж ажиллах,

2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хуулийн болон УСНББОУС нэмэлт өөрчлөлтүүдийг тусгаж шинэчилнэ.

3. Балансын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Бараа материалын дансанд 41.8 сая төгрөгийн ашиглалтад байгаа хангамжийн зүйлс (бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс)-ийг бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", НББОУС 2-ын 6 (в)-т "үйлдвэрлэлийн дамжлага эсвэл үйлчилгээ үзүүлэхэд ашиглах гэж байгаа материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа хөрөнгө" гэж заасантай тус тус нийцэхгүй, "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Эрсдэл:

- Бараа материалыг буруу ангилан бүртгэсэн байх,
- Санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх,

3.3 Өгсөн зөвлөмж:

Зардлаар хүлээн зөвшөөрөх ёстой хангамжийн зүйлс (бага үнэтэй зүйлс)-ийг холбогдох тайлант хугацаанд бүртгэлд тусгаж байх, УСНББОУС12-ийг дагаж мөрдөх

3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

2018 оны жилийн эцсийн тооллогоор зарлагадах шаардлагатай хангамжийн зүйлсийн жагсаалтыг гаргасан, мөн 2019 онд зөвлөмжийг мөрдөж ажиллана.

4. Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт

4.1 Илрүүлэлт:

Гэрээт ажиллагсдад олгосон цалингаас нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй, хувь хүний орлогын албан татвар тооцож төлсөн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын хэлбэр, хамрах хүрээ 4.6-д “Үндсэн ажлаас гадуур байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу давхар ажил эрхэлж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна” гэж заасныг зөрчсөн, “иж бүрэн байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

4.2 Эрсдэл:

- Холбогдох хууль журмыг хэрэгжүүлж ажиллаагүй.

4.3 Өгсөн зөвлөмж:

Гэрээт ажиллагсдад олгосон цалингаас Нийгмийн даатгалын хуулийн 4 дүгээр зүйл 4.6 дах заалтын дагуу нийгмийн даатгалын шимтгэл суутгаж, нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлэх,

4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 23 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, иргэд төрийн үйлчилгээг тасалдалгүй түргэн шуурхай хүргэх үүднээс Мэдээлэл Холбооны сүлжээ ХХК-ийн өмчлөлийн хөдөө орон нутгийн болон Улаанбаатар хотын зарим дүүргүүдэд байрлах байранд ТҮЦ машиныг байршуулан, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн ажилтнуудаар ТҮЦ машины өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хариуцуулан ажиллаж байна. Дээрх ажилтнуудын цалингаас НДШ-ийг суутгах тухай Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-д тодорхой саналыг тавьж шийдвэрлэхээр ажиллаж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон
санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	212,162,860.95	287,939,988.51
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	12,189,500.00	11,191,503.00
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	201.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,504,500.00	500.00
31210	Төгрөг	2,504,500.00	500.00
31213	Арилжааны банк дахь харилцах	2,504,500.00	500.00
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	9,685,000.00	11,190,802.00
33	АВЛАГА	33,306,078.97	23,949,392.82
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	3,049,000.00	3,668,500.00
33500	Бусад авлага	30,257,078.97	20,280,892.82
33510	Байгууллагаас авах авлага	30,257,078.97	20,280,892.82
34	УРЬДЧИЛГАА	0.00	2,990,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	0.00	2,990,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	166,667,281.98	249,809,092.69
35400	Хангамжийн материал	166,667,281.98	249,809,092.69
35410	Бичиг хэргийн материал	35,651,054.79	19,318,898.25
35420	Аж ахуйн материал	19,041,239.00	42,895,074.35
35430	Сэлбэг хэрэгсэл	103,525,587.19	173,527,120.09
35440	Түлш, шатах тослох материал	8,449,401.00	14,068,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,580,131,096.66	3,671,477,581.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,580,131,096.66	3,671,477,581.74
39200	Биет хөрөнгө	4,323,505,257.12	3,529,658,356.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,143,735,807.00	2,053,120,168.95
39202	Хуримтлагдсан элэгдэл	-250,907,510.52	0.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	98,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-3,433,333.34
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	13,072,428,133.07	13,593,641,108.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	-10,683,176,340.52	-12,240,823,310.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	126,914,431.71	126,914,431.71
39208	Хуримтлагдсан элэгдэл	-85,566,263.62	-98,237,708.74
39217	Ном	77,000.00	77,000.00
39300	Биет бус хөрөнгө	256,625,839.54	141,819,224.84
39301	Програм хангамж	1,748,818,811.01	1,748,818,811.01
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,492,192,971.47	-1,732,530,086.17
39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	125,530,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,792,293,957.61	3,959,417,570.25
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,016.38	12,163,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,016.38	12,163,000.00

41300	Өглөг	10,016.38	12,163,000.00
41360	Бусад өглөг	10,016.38	12,163,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	12,090,500.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	72,500.00
41364	НДШ-ийн өглөг	10,016.38	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,792,283,941.23	3,947,254,570.25
51	Засгийн газрын хувь оролцоо	4,792,283,941.23	3,947,254,570.25
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,714,633,065.33	6,840,163,565.33
51200	Хуримтлагдсан үр дүн	-1,922,349,124.10	-3,089,044,797.59
51210	Өмнөх үеийн үр дүн	-517,153,555.80	-1,922,349,124.10
51220	Тайлант үеийн үр дүн	-1,405,195,568.30	-1,166,695,673.49
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.00	196,135,802.51
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,792,293,957.61	3,959,417,570.25

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,182,072,420.00	4,099,485,455.54
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,581,274,120.00	1,896,155,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,581,274,120.00	1,896,155,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,581,274,120.00	1,896,155,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,581,274,120.00	1,896,155,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,600,798,300.00	2,203,330,355.54
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,600,798,300.00	2,203,330,355.54
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,600,798,300.00	2,203,330,355.54
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,587,267,988.30	5,266,181,129.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,587,267,988.30	5,266,181,129.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,395,467,035.46	5,266,181,129.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,211,057,510.81	1,235,285,872.91
210101	Үндсэн цалин	906,078,974.65	1,113,346,109.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,814,000.00	43,623,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	272,164,536.16	78,316,763.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	130,143,195.38	143,639,267.56
210201	Тэтгэврийн даатгал	130,143,195.38	143,639,267.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	388,171,289.67	407,797,255.51
210301	Гэрэл, цахилгаан	265,918,766.76	287,371,705.46
210302	Түлш, халаалт	53,149,160.00	54,282,500.00
210303	Цэвэр, бохир ус	6,713,712.91	5,923,050.05
210304	Байрны түрээс	62,389,650.00	60,220,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	331,017,362.39	400,098,011.22
210401	Бичиг хэрэг	225,149,398.29	274,948,034.54
210402	Тээвэр, шатахуун	66,537,000.00	64,186,401.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,715,544.10	52,620,443.03
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,615,420.00	8,343,132.65
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	365,633,022.98	427,351,163.10
210604	Урсгал засвар	365,633,022.98	427,351,163.10
2107	Томилолт, зочны зардал	21,728,022.00	5,874,500.00
210701	Гадаад албан томиллолт	10,852,872.00	0.00
210702	Дотоод албан томиллолт	10,875,150.00	4,058,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	1,816,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	575,981,957.50	767,690,145.58
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	95,922,624.00	100,923,512.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,960,000.00	5,960,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	953,400.00	888,030.00

Үндэсний дата төв УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210804	Тээврийн хэрэгслийн татвар	65,000.00	40,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	467,672,278.50	653,378,962.58
210807	Газрын төлбөр	0.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,408,655.00	6,499,641.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,371,734,674.73	1,878,444,913.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	180,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,105,035.00	28,332,120.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,349,629,639.73	1,849,932,793.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	191,800,952.84	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	191,800,952.84	0.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	105,329,000.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	86,471,952.84	0.00
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-1,405,195,568.30	-1,166,695,673.49
	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-1,405,195,568.30	-1,166,695,673.49

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон
санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,599,788,917.00	5,053,988,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,998,990,617.00	2,408,440,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,998,990,617.00	2,408,440,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,998,990,617.00	2,408,371,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,998,990,617.00	2,408,371,200.00
120009	Бусад орлого	0.00	69,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,600,798,300.00	2,645,548,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,600,798,300.00	2,645,548,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,600,798,300.00	2,645,548,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,785,197,967.00	4,435,373,821.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,785,197,967.00	4,435,373,821.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,145,244,071.27	3,480,881,933.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,190,588,000.00	1,213,354,458.61
210101	Үндсэн цалин	896,133,600.00	1,073,832,412.73
210102	Нэмэгдэл	0.00	89,428,047.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,402,000.00	50,093,998.00
210104	Урамшуулал	0.00	0.00
210105	Гэрээт ажлын хөлс	265,052,400.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	130,964,900.00	145,771,199.09
210201	Тэтгэврийн даатгал	83,341,300.00	145,771,199.09
210202	Тэтгэмжийн даатгал	11,905,900.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,524,700.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,381,200.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	23,811,800.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	440,697,273.67	414,504,555.51
210301	Гэрэл, цахилгаан	276,617,561.76	287,221,705.46
210302	Түлш, халаалт	93,481,349.00	56,171,500.00
210303	Цэвэр, бохир ус	6,713,712.91	5,946,350.05
210304	Байрны түрээс	63,884,650.00	65,165,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	211,724,878.11	208,299,843.03
210401	Бичиг хэрэг	107,157,300.00	100,658,821.52
210402	Тээвэр, шатахуун	62,706,600.00	63,001,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,293,988.11	39,001,422.51
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	803,000.00	935,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,763,990.00	4,703,299.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,282,804.99	321,422,574.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,541,070.99	11,205,969.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,146,820.00	7,289,936.00

Үндэсний дата төв УТУГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	283,594,914.00	302,926,669.00
2107	Томилолт, зочны зардал	16,039,150.00	5,874,500.00
210701	Гадаад албан томилолт	5,164,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	10,875,150.00	3,162,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	2,712,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	827,153,157.50	1,143,243,263.58
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	95,638,825.00	103,878,323.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,960,000.00	5,960,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	891,000.00	888,030.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	127,400.00	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	576,808,103.50	884,755,887.58
210807	Газрын төлбөр	833,712.00	833,712.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,444,940.00	5,625,811.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	144,449,177.00	141,261,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,793,907.00	28,411,540.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,793,907.00	28,411,540.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	639,953,895.73	954,491,887.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,681,342.89	19,757,643.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,681,342.89	19,757,643.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	191,800,952.84	442,217,744.46
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	105,329,000.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	86,471,952.84	442,217,744.46
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	428,471,600.00	492,516,500.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	428,471,600.00	492,516,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	814,590,950.00	618,614,978.72
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	810,625,910.00	619,612,975.72
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	810,625,910.00	619,612,975.72
2200	Дотоод эх үүсвэрээр	810,625,910.00	619,612,975.72
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	810,625,910.00	619,612,975.72
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-810,625,910.00	-619,612,975.72
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	3,965,040.00	-997,997.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,224,460.00	12,189,500.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,189,500.00	11,191,503.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон
санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,714,633,065.33	0,00	-517,153,555.80	6,197,479,509.53
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	0,00	0,00	0,00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,714,633,065.33	0,00	-517,153,555.80	6,197,479,509.53
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00,00	0,00	00,00	00,00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00,00	0,00	00,00	00,00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	0,00	00,00	00,00
Тайлант үеийн үр дүн	00,00	0,00	-1,405,195,568.30	-1,405,195,568.30
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,714,633,065.33	0,00	-1,922,349,124.10	4,792,283,941.23
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,714,633,065.33	0,00	-1,922,349,124.10	4,792,283,941.23
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,840,163,565.33	0,00	-1,922,349,124.10	4,792,283,941.23
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00,00	196,135,802.51	00,00	196,135,802.51
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	125,530,500.00	00,00	00,00	125,530,500.000,00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	00,00	00,00	00,00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00,00	00,00	00,00	00,00
Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	-1,166,695,673.49	-1,166,695,673.49
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,840,163,565.33	196,135,802.51	-3,089,044,797.59	3,947,254,570.25

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон
санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,326,870,100.00	4,000,985,199.54	325,884,900.46	92.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,326,870,100.00	4,000,985,199.54	325,884,900.46	92.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,326,870,100.00	4,000,985,199.54	325,884,900.46	92.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,214,760,000.00	1,213,354,458.61	1,405,541.39	99.88
210101	Үндсэн цалин	1,071,066,000.00	1,073,832,412.73	-2,766,412.73	100.26
210102	Нэмэгдэл	93,600,000.00	89,428,047.88	4,171,952.12	95.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	50,094,000.00	50,093,998.00	2.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	145,771,200.00	145,771,199.09	0.91	100.00
210201	Тэтгэврийн даатгал	97,180,800.00	145,771,199.09	-48,590,399.09	150.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,147,600.00	0.00	12,147,600.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,718,100.00	0.00	9,718,100.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,429,500.00	0.00	2,429,500.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,295,200.00	0.00	24,295,200.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	610,703,600.00	414,504,555.51	196,199,044.49	67.87
210301	Гэрэл, цахилгаан	408,879,900.00	287,221,705.46	121,658,194.54	70.25
210302	Түлш, халаалт	112,860,000.00	56,171,500.00	56,688,500.00	49.77
210303	Цэвэр, бохир ус	8,972,100.00	5,946,350.05	3,025,749.95	66.28
210304	Байрны түрээс	79,991,600.00	65,165,000.00	14,826,600.00	81.46
2104	Хангамж, бараа материалын зардал	220,288,500.00	208,299,843.03	11,988,656.97	94.56
210401	Бичиг хэрэг	106,179,500.00	100,658,821.52	5,520,678.48	94.80
210402	Тээвэр, шатахуун	62,977,600.00	63,001,000.00	-23,400.00	100.04
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	45,813,200.00	39,001,422.51	6,811,777.49	85.13
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,380,000.00	935,300.00	444,700.00	67.78
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,938,200.00	4,703,299.00	-765,099.00	119.43
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	321,514,700.00	321,422,574.00	92,126.00	99.97
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,612,800.00	11,205,969.00	-593,169.00	105.59
210602	Тавилга	0.00	0.00	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,075,000.00	7,289,936.00	-214,936.00	103.04
210604	Урсгал засвар	303,826,900.00	302,926,669.00	900,231.00	99.70
2107	Томилолт, зочны зардал	17,044,000.00	5,874,500.00	11,169,500.00	34.47

Үндэсний дата төв УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	14,039,800.00	3,162,000.00	10,877,800.00	22.52
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,004,200.00	2,712,500.00	291,700.00	90.29
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн үйлчилгээний хураамж	1,767,167,300.00	1,663,346,529.30	103,820,770.70	94.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	170,686,000.00	103,878,323.00	66,807,677.00	60.86
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,960,000.00	5,960,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	891,000.00	888,030.00	2,970.00	99.67
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	0.00	150,000.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	40,000.00	4,000.00	90.91
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,407,276,300.00	1,405,968,863.30	1,307,436.70	99.91
210807	Газрын төлбөр	990,000.00	833,712.00	156,288.00	84.21
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,752,000.00	4,516,101.00	235,899.00	95.04
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	176,418,000.00	141,261,500.00	35,156,500.00	80.07
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,620,800.00	28,411,540.00	1,209,260.00	95.92
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,620,800.00	28,411,540.00	1,209,260.00	95.92
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,326,870,100.00	4,001,027,412.54	325,842,687.46	92.47
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,645,548,100.00	2,645,548,100.00	0.00	100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,645,548,100.00	2,645,548,100.00	0.00	100.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,681,322,000.00	1,355,479,312.54	325,842,687.46	80.62
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,681,322,000.00	1,355,479,312.54	325,842,687.46	80.62
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	12,189,500.00	-12,189,500.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	11,191,503.00	-11,191,503.00	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	132.00	132.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	66.00	66.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	60.00	60.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	66.00	66.00	0.00	100.00
650013	УТҮГ	66.00	66.00	0.00	100.00

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон
санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	118,157,643.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,757,643.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,757,643.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,757,643.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,757,643.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	98,400,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	98,400,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	98,400,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	118,157,643.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	118,157,643.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	118,157,643.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Аудитын нэр:	Үндэсний дата төв УТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит		
Огноо:	2019.03.14	Аудитын код:	САГ-2019/47/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Үндэсний дата төв УТҮГ		Сая төгрөгөөр:

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
				Албан тушаал	Овог нэр
А	3	4	8	9	10
1	ТҮЦ машины засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслийн үнэ, бэлэн мөнгө уншигчийн машины үнэ, урсгал засварын ажиллууд зэрэг худалдан авалтанд тендер зарлаагүй.	373.3	Зөвлөмж өгөх	Захирал	Б.Батжаргал
2	Гэрээт ажиллагсад олгосон цалинг цалингийн зардалд бүртгэсэн боловч НДШ суутгаагүй, ХХОАТ тооцож төлсөн байна.		Зөвлөмж өгөх	Захирал	Б.Батжаргал
3	Бараа материалын дансанд 41,894.8 мянган төгрөгийн ашиглалтад байгаа бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс бүртгэгдсэн байна.	41.9	Зөвлөмж өгөх	Захирал	Б.Батжаргал
4	НББ-ийн бодлогын баримт бичигт шинэчлэлт, сайжруулалт хийгдээгүй байна. СТОУС (НББОУС) болон НББ болон бусад хуулиуд байнга шинэчлэгдэж байна. (2016 онд хийсэн)		Зөвлөмж өгөх	Захирал	Б.Батжаргал
	Дүн	415.2			

